



Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэгийн үнсэн санг нүүлгэн шилжүүлэх, шинээр үнсэн сан үүсгэх ажлын даалгавар

2024.07.26

Мөрөн сум



№	Ажлын нэр	Тайлбар
1.	Үндэслэл	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.3.4, 9.3.10 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 08 дугаар тэмдэглэл, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны 04 дүгээр албан даалгавар, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын 2024 оны 5 дугаар сарын 8-ны А/234 дүгээр захирамжийн дагуу хэрэгжилтийг хангах8 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/554 дүгээр тушаал
2.	Зорилго	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багийн нутагт орших Элстийн арын "Хог хаягдлын төвлөрсөн цэг-ийн 117535 м ³ талбайн үнсэн санг дарж булах, шинээр 3.7 га талбайд үнсэн сан байгуулах
3.	Хамрах хүрээ	Хог хаягдлын төвлөрсөн цэг
4.	Ажлын даалгавар	<p>Дараах ажил нь хоёр үе шаттай хийгдэнэ.</p> <p>Нэгдүгээр үе шат: Үнсэн санг нүүлгэн шилжүүлэх</p> <p>Хоёрдугаар үе шат: Шинэ үнсэн сан үүсгэх</p> <p>Нэгдүгээр үе шатад дараах ажлууд хийгдэнэ. Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийт тархсан үнсний талбай 10 га бөгөөд үүнээс үнсний овоолго хэсэг 117,535 м³ талбайг хамарч байна 2. Тархсан талбайн үнсийг зөөвөрлөн нүүлгэн шилжүүлж 1,4 га овоолго хэсэгт төвлөрүүлэх 3. 1,4 га талбайд төвлөрүүлсэн үнсийг шороон далан үүсгэж 1 метрийн зузаантай шороогоор хучилт хийх. 4. Үнсний тоосонцор нь салхинд хийсч агаар бохирдуулан иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг учир чийгшүүлж, тоосжилтыг дарж үнсэн сангийн талбайд асгаж байна. <p>Хоёрдугаар үе шатад дараах ажлууд хийгдэнэ</p> <p>Сонгогдсон байршилд өргөн 64м, урт 74м, гүн 6м хэмжээтэй үнсэн сан байгуулах бөгөөд жилд дунджаар 7000-8000 тн үнс булахаар төлөвлөгдсөн байна.Үнсэн санг байгууллахад дараах шаардлага тавигдана. Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнсэн сангийн талбайг бэлтгэх

		<ul style="list-style-type: none"> 2. Үнсэн сангийн шороон далангийн өндөр: 1.5 метр 3. Үнсэн сангийн ашиглалтын хугацаа: 3 жил 4. 8 метр өргөний хэмжээтэй орох, гарах цэг хийх 5. 3 метрээр 2 үетэй давхарга үүсгэх 6. Үелэж тойрог хэлбэрийн орц, гарц гаргаж өгөх <ul style="list-style-type: none"> • Барилгын тухай хууль • Хог хаягдлын тухай хууль
5.	Тусгай шаардлага	<p>Дээрх ажлыг гүйцэтгэхэд дараах мэргэжил, ур чадварын шаардлага тавигдана.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 1. Ижил төстэй ажлын туршлагатай байх. 2. Мэргэжлийн мэргэшсэн багтай байх. 3. Дээрх ажлыг гүйцэтгэхэд холбогдох тусгай зөвшөөрөлтэй байх. 4. Ажилд тавигдах шаардлагын дагуу скиз зураг бэлтгэж, ажлын төлөвлөгөө үе шатны хуваарь, мэргэшсэн төсөвчнөөр төсөв батлуулж тендерийн баримт бичигт ирүүлнэ.
6.	Хүлээгдэж байгаа үр дүн	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багийн нутагт орших Элстийн арын "Хог хаягдлын төвлөрсөн цэг-ийн 10 га талбайд тархсан үнсийг нүүлгэн шилжүүлж, шинээр 3.7 га талбайд үнсэн сан байгуулсан байна.
7.	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>2 үе шаттай байна.</p> <ul style="list-style-type: none"> 1. 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд 2. 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн хооронд
8.	Захиалагч байгууллага	Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны /Улсын төсвийн хөрөнгөөр/
9.	Шаардагдах санхүүжилт	500,000,000.00 /таван зуун сая төгрөг/

Ажлын даалгавар боловсруулсан:

Ажлын хэсгийн ахлагч:

Нарийн бичгийн дарга:

 (Ч.Батсүх)
 (Б.Анхцэцэг)